



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 4/497

Зуунмод

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2015 онд хийсэн ажлыг дүгнэж, 2016 онд хийх ажлын чиглэл батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчидын хуралын 12-р хуралдааны 03 тоот тогтоолын хавсралт Төв аймийн газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэлийн 10-р бүлэгийн 10.2 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 29.1.6, 29.2, дохь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас хөндөгджээ эвдрэлд орсон, нөхөн сэргээсэн, нөхөн сэргээгдээгүй үлдсэн, эзэнгүй орхигдсон газрын хэмжээ, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газрын төлбөр төлдөгтгүй тусгай зөвшөөрлүүдийн шалтгааныг тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

М.Хүрэлбаатар -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

**Нарийн бичгийн дарга:**

М.Цогжавхаа -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

**Гишүүд:**

Ж.Даш-Яйчил -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Б.Насанжаргал -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженер хайгуул, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Т.Гансүх -Сэргэлэн сумын Засаг дарга

Б.Цэрэнбат -Алтанбулаг сумын Засаг дарга

Д.Болормаа -Заамар сумын Засаг дарга

Н.Алтанчимэг -Эрдэнэ сумын Засаг дарга

Б.Шинэгэрэл -Баян сумын засаг дарга

Сумдын Байгаль орчны улсын байцаагч

01 ; 1578

Сумдын газрын даамал

Багийн Засаг дарга нар

2.Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас хөндөгдөж эвдрэлд орсон, нөхөн сэргээсэн, нөхөн сэргээгдээгүй үлдсэн, эзэнгүй орхигдсон газрын хэмжээ, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газрын төлбөр төлдөггүй тусгай зөвшөөрлүүдийн шалтгааныг тогтоож түүний буруутай эзэн, учирсан хохирлын талаар тодорхой дүгнэлт гаргаж ажлын тайланг 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаануудад, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /М.Хүрэлбаатар/-д даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргийн үүргийн түр орлон гүйцэтгэгч Ч.Баярсайхан, Ажлын хэсгийн ажиллах нөхцөл бололцоогоор /шатахуунаар/ хангаж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ю.Бямбацогт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ